



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Эрх чөлөөтэй
байхын тулд хуульд
захирагдах хэрэгтэй
Ж.Амарсанаа

Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn

Хууль зүйн мэдээ сонин

2023.05.01



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ДОКТОРУУДЫН

ЦУВРАЛ ЛЕКЦ: КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙ



Б.ОЮУНЖАРГАЛ
МУИС ХЭС-ийн АХЛАХ БАГШ, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ
ДОКТОР

сэдэв: МОНГОЛ УЛС ДАХЬ ГҮЙЦЭТГЭХ
УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



М.ТҮВШИНЖАРГАЛ
СЭЗИС-ийн АХЛАХ БАГШ, ХУУЛЬ ЗҮЙН УХААНЫ ДОКТОР

сэдэв: КОМПАНИ НЭГДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ
АРИЛЖААНЫ ЭРХ ЗҮЙ БА ӨРСӨЛДӨӨНИЙ ЭРХ ЗҮЙН
ҮҮДНЭЭС СУДЛАХ НЬ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



2023.05.08-нд
10:00-11:30 ЦАГТ
Хуульчдын танхимд



LIVE

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ФЕЙСБҮҮК ХУУДСААР ШУУД ДАМЖУУЛНА.

Хууль зүйн англи хэлний сургалтыг 11 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа



Хууль зүйн үндэсний хүрээлэн хуульчдад хууль зүйн англи хэлний бичгийн болон бусад чадвараа хөгжүүлэхэд нь түлхэц үзүүлэх, арга барилаа олоход нь чиглэл өгөх зорилгоор 2012 оноос эхлэн Хууль зүйн англи хэлний сургалтыг зохион байгуулж байна. Энэ удаагийн сургалтыг 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 27-ны өдрийг дуустал зохион байгууллаа.

Хууль зүйн англи хэлний сургалтыг “Гэрээний эрх зүй”, “Компанийн эрх зүй”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Маргаан шийдвэрлэлт” зэрэг сэдвээр англи хэл дээрх бичвэр унших, гол агуулгыг ярилцах, англи хэл дээр баримт бичиг боловсруулах, англиас монгол, монголоос англи хэл дээр орчуулгын практик хийлгэх байдлаар МУИС-ийн ХЭС-ийн багш, LL.M. Э.Туулайхүү заав.

Сургалцагчид хууль зүйн бичлэг (Legal writing)-ийн хэв маяг, арга техникийн үндсэн ойлголтыг авч, англи хэлний хууль зүйн нэр томъёоны хэрэглээ, орчуулах арга зүйд суралцлаа.

ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ТӨВ АЙМАГТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хуульзүйнүндэснийхүрээлэн нь Төв аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтыг 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтад Сити их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор /Ph.D./ Б.Одонгэрэл, Монголын Хуульчдынхолбооныгишүүн, Хууль зүйн ухааны магистр /LL.M./ Э.Түмэнбаяр, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн ухааны Магистр

/LL.M./ Б.Мөнхзаяа, ХЗҮХ-ийн Арга зүйч багш, Хууль зүйн ухааны Магистр /LL.M./ Д.Цэцэгдарь нар хичээл зааж, Төв аймгийн 140 эрх зүйн хөтөч танхимаар болон цахимаар хамрагдлаа.

Сургалтыг дараах сэдвээр заалаа.

Гэрээний эрх зүй, төрийн байгууллагаас иргэн хуулийн этгээдтэй байгуулах гэрээний хэлбэр, түүнд тавигдах шаардлага; Х ө д ө л м ө р и й н тухай хуулийн

шинэчилсэн найруулга; Дүрэм, журам, дүгнэлт зөвлөмж боловсруулах арга зүй; Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ; Захиргааны акт, хэм хэмжээний акт гаргах, хянах арга зүй; Хүний мэдээлэл хамгаалах тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг орон нутагт хэрэгжүүлэх; Хууль тогтоомжийн хэрэглээ, практикийн зарим асуудал.



НИЙСЛЭЛИЙН 33 ДУГААР СУРГУУЛИЙН 12 ДУГААР АНГИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ”, “ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО, ЗӨРЧИГДСӨН ЭРХЭЭ ХАМГААЛУУЛАХ БОЛОМЖ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5.11, ХЗҮХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу тус сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвтэй хамтран улсын хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулж байна.

Сургалтын зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн

сурагчдад Үндсэн хууль болон бусад хуулийн үүрэг, ач холбогдлыг таниулах, өөрийн болон бусдын эрхийг хэрхэн хамгаалах, түүнчлэн үүргээ чанд биелүүлдэг хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино. Энэ удаа Улсын тэргүүний лаборатори 33 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Хүүхэд хамгааллын тогтолцоо, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломж” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Нийт 50 гаруй сурагч хамрагдсан.

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Ц.Энхжин, МУИС-ийн

ХЗС-ийн 4 дүгээр түвшний оюутан Д.Даваадорж, Б.Гэрэлт-Од, Б.Гүнтөгөлдөр, МУИС-ийн ХЗС-ийн 5 дугаар түвшин, Бизнесийн сургуулийн 5 дугаар түвшний оюутан П.Чулуунчимэг нар хичээл заав.

Сургалтын сэдэв:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, танхайрах гэмт хэрэг, мансууруулах бодисын хор хөнөөл/-ийн ойлголт;

Хүүхэд хамгааллын тогтолцоо, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломж;

Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;

Мэргэжил сонголт сэдвээр анхан шатны ойлголт, мэдээллийг тус тус хүргэлээ.



УДШ-ИЙН ШҮҮГЧ НЯМДООГИЙН БАЯРМААГИЙН ДОКТОРЫН ХҮНДЭТГЭЛИЙН ЛЕКЦ, ШИНЭ БҮТЭЭЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр УДШ-ийн шүүгч Нямдоогийн Баярмаагийн хууль зүйн ухааны докторын хүндэтгэлийн лекц, шинэ бүтээлийг танилцуулах арга хэмжээг Хууль зүйн үндэсний хүрээлэн, УДШ-ийн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн хамтран Хуульчдын танхимд зохион байгууллаа. Тус арга хэмжээг нээж УДШ-ийн Иргэний хэргийн танхимын тэргүүн, шүүгч Г.Алтанчимэг, УДШ-ийн Захиргааны хэргийн танхимын шүүгч, доктор

(LL.D) Ц.Цогт нар, докторын ажил болон бүтээлүүдийг дүгнэж гавьяат хуульч, дэд профессор Д.Наранчимэг, МУИС-ийн ХЗС-ийн захирал, доктор Б.Амарсанаа нар үг хэлэв. Мөн арга хэмжээнд УИХ, Үндсэн хуулийн цэц, УДШ, ШЕЗ, ХЭҮК, МУИС-ийн ХЗС, Отгонтэнгэр ИС зэрэг байгууллагын төлөөлөл оролцож баяр хүргэв. Н.Баярмаа нь “Development of Real Property Law in Mongolia: Toward a Unified Foundation” буюу “Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн эрх зүйн хөгжил: Суурь

зарчмыг нэгтгэх нь” сэдвээр 2022 онд Япон Улсын Нагоягийн Их Сургуулийн Хууль зүйн ахисан түвшний сургуульд хууль зүйн ухааны доктор(LL.D)-ын зэрэг хамгаалсан. Докторын хүндэтгэлийн лекцээс гадна “Арилжааны эрх зүйн зарим асуудал” түүвэр эмхтгэл 1, “Үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн зарим асуудал” түүвэр эмхтгэл 2 зэрэг бүтээлүүдээ танилцууллаа. Хууль зүйн ухааны доктор Н.Баярмаа танд цаашдын эрдэм шинжилгээний ажилд нь өндөр амжилтыг хүсье!

“ЭРХ ЗҮЙН КОДИФИКАЦИ ХИЙХ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Төв аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Эрх зүйн кодификаци хийх арга зүй, аргачлал” сэдэвт захиалгат сургалтыг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ профессор Т. Мэндсайхан хичээл зааж, Төв аймгийн хууль, эрх зүйн хэлтсийн 17 албан хаагчид хамрагдлаа.



ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ААР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Хууль зүй, дотоод хэргийн яамны 2023 оны Эрх зүйн, сургалт сурталчилгааны төлөвлөгөөний 8-т заасны дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн 4 дүгээр сарын 25-ны өдөр Д.Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын Нийтийн Төв Номын Сангийн захиалгаар төрийн үйлчилгээний албан хаагч нарт Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-аар сургалт зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Арга зүйч багш, хууль зүйн ухааны магистр (LL.M) Д.Цэцэгдарь хичээл заав. Нийт 32 албан хаагч сургалтад хамрагдлаа.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн ХЗС-ийн практик сургалтын төвтэй хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10-т тус тус заасны дагуу 104 дүгээр сургуулийн 80 гаруй сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг өнөөдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Э.Цэрэндүзээ, МУИС-ийн ХЗС-ийн 4 дүгээр түвшний оюутан Н.Энхбаяр нар хичээл заав.

Сургалтаар:

- Зөв хандлагатөлөвшүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, танхайрах гэмт хэрэг, мансууруулах бодисын хор хөнөөл/-ийн ойлголт;
- Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэдвээр анхан шатны ойлголт, мэдээллийг тус тус хүргэлээ.



НИЙСЛЭЛИЙН 115 ДУГААР СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “СУРГУУЛИЙН ОРЧИНД БУСДЫГ ДЭЭРЭЛХЭХ, ЯЛГАВАРЛАЛ ҮҮСГЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Гэмт хэргээс урьдчилан хэмжээнд үе шаттайгаар байгууллаа. Нийт 100 сэргийлэх ажлыг зохицуулах зохион байгуулж байна. гаруй сурагч хамрагдсан. зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5.11, ХЗҮХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу тус сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвтэй хамтран улсын Энэ удаа Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори 115 дугаар сургуулийн сурагчдад “Сургуулийн орчинд бусдыг дээрэлхэх, ялгаварлал үүсгэхээс урьдчилан сэргийлэх тухай” сэдэвт сургалтыг зохион Сургалтын зорилго нь Сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Н.Цогт-Очир зохион байгуулж, МУИС-ийн ХЗС-ийн 4 дүгээр түвшний оюутан Г.Хулан, Т.Анударь нар хичээл заав. Сургалтын сэдэв:

- Үе тэнгийн дээрэлхэлт
- Электрон тамхины хор хөнөөл, эрх зүйн зохицуулалтын талаарх анхан шатны ойлголт, мэдээллийг тустус хүргэлээ.



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ЭМ АЙ Ю” СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.10, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.5.11, ХЗҮХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 5.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу тус сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, МУИС-ийн ХЗС-ийн Практик сургалтын төвтэй хамтран улсын

хэмжээнд үе шаттайгаар зохион байгуулж байна. Сургалтын зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Үндсэн хууль болон бусад хуулийн үүрэг, ач холбогдлыг таниулах, өөрийн болон бусдын эрхийг хэрхэн хамгаалах, түүнчлэн үүргээ чанд биелүүлдэг хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэхэд оршино. Энэ удаа Ерөнхий боловсролын “Эм Ай Ю” сургуулийн ахлах ангийн сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг өнөөдөр

зохион байгууллаа. Нийт 20 гаруй сурагч хамрагдсан.

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн ажилтан Д.Батням, хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны мэргэжилтэн Э.Цэрэндүзээ, МУИС-ийн ХЗС-ийн 4 дүгээр түвшний оюутан Г.Хулан, М.Ариунзаяа нар хичээл заав. Сургалтын сэдэв:

- Зөв хандлага төлөвшүүлэх,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх /хулгай, дээрэм, танхайрах гэмт хэрэг, /-ийн ойлголт, мэдээллийг тус тус хүргэлээ.

